



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 4 сарын 09 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Хуралдааныг цахимаар
зохион байгуулах тухай


Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2021 оны 08 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2. Цахим хуралдааны бэлтгэлийг хангаж ажиллахыг Нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/-д даалгасугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000083